

Хумболтын Их сургуулийн Монгол судлалын ахмад профессор Dr. sc. Ута Шёне 2024 оны 4-р сарын 7-нд таалал төгсөв. Профессор Ута Шёне нь 40 гаруй жилийн турш Берлиний Хумболтын их сургуульд ажилласан. 1990-ээд онуудад тус сургууль дээр явагдсан бүтцийн өөрчлөлтийн дараа тэрээр монгол судлалын цорын ганц багшаар үлдэж, олон оюутнуудад монгол хэл, соёл, түүхийн талаар хичээл зааж хожим тэтгэвэртээ гарсан ч үргэлжлүүлэн хийж байв. Мөн олон тооны магистр, бакалавр, мастерийн төгсөлтийн ажлууд, диссертацийн ажлыг удирдан явуулсан нь зарим залуу судлаачдад ирээдүйнх нь эрдмийн замыг нээж өгсөн.

Ута Шёне нь нийгэм-улс төрийн асуудал, ялангуяа Монголын нийгэм дэх жендэрийн асуудлаар голчлон судалгааны ажлууд хийж байв. Тэрээр Монголын залуу эрдэмтэдтэй хамтран төрөл бүрийн судалгааны төсөл дээр ажиллаж байсан бөгөөд тэд хожим нь эх орондоо нэр хүндтэй эрдэмтэн болтлоо өссөн. Хумболтын их сургуульд Монгол судлал өнөөг хүртэл оршиж байгаа нь профессор Uta Schöne-гийн гол гавъяа юм.

Түүний олон шавь нар, хамт олон, хамтын нөхөр, ажиллагсдын өмнөөс түүний нөхөр, үр хүүхэд, ач зээ нарт нь гүн эмгэнэл илэрхийлье.